

## ЭМГЭНЭЛ

---

Хэвлэлийн мэдээ  
Нова Скошиа муж, Халифакс хот  
2022.05.02

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) -ийн үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн дарга асан, бидний хүндэт нөхөр Жон Кристофер (Крис) Кован нь 2022 оны 4 сарын 28-ны өдөр таалал төгсөж, бидэнд хүнд гарз тохиолоо.

Эрдэнэ Ресурсийн Ерөнхийлөгч ба Гүйцэтгэх захирал Петер Акерли: “Крисийн үзэл баримтлал, хамт олноо гэсэн сэтгэл, хичээл зүтгэл, шаргуу хөдөлмөр, түүний оруулсан хувь нэмэргүйгээр манай компани үүсгэн байгуулагдахгүй байсан. Крис нь олон улсын уул уурхайн салбарт нэр хүндтэй удирдагч, зөвлөгч байв.”

“Түүний ажил хөдөлмөрийн замнал нь Атлантын далайг хөлөг онгоцоор туулан Өмнөд Африкийн очир эрдэнийн уурхайгаас эхлэн, Фалконбридж (Falconbridge), Сидбюри (Sudbury), Юнайтед Кэно Хилл (United Keno Hill), Нью Кебек Раглан (New Quebec Raglan), Индасмин (Indusmin)-д удирдах албан тушаал хашиж, Филиппин, Австрали улсуудад олон улсын хайгуул хариуцсан захирал, олон улсын зөвлөхөөр ажиллан асар их туршлага хуримтлуулсан төдийгүй амьдралд хайртай, хүнлэг нэгэн гэдгээрээ олноо хүндлэгдсэн эрхэм байсан”.

Эрдэнэ Ресурсийн хамт олны хувьд эрхэм нөхрөө алдан, нөхөж баршгүй хүнд гарз тохиолоо. Түүний хийж бүтээсэн үйлс, түүнтэй хамт хуваалцсан гайхалтай дурсамжууд хамт олон бидний сэтгэл зүрхэнд тодоос тод гэрэлтэн үлдэх болно. Эрдэнэ Ресурсийн нийт хамт олны зүгээс талийгаачийн таван хүү болон гэр бүл, төрөл төрөгсдөд гүн эмгэнэл илэрхийлье.

### Эрдэнэ Ресурсийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд 2 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт [www.erdene.com](http://www.erdene.com) -оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН  
ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН  
МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал  
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: [info@erdene.com](mailto:info@erdene.com)

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>